



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/869

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мобиком корпорацийн ерөнхий захирал Тацуяа Хамадаг тэргүүтэй албаны хүмүүсийг хүлээн авч уулзасан зардалд 236 245 төгрөг, БНХАУ-ын Цонж аймгийн төлөөлөгч нартай уулзасан уулзалтын зардалд 790 250 төгрөг, Швейцарийн хөгжлийн агентлагийн төлөөлөгчидтэй хийсэн уулзалтын зардалд 859 450 төгрөг, ХХААЯамтай хамтран хэрэгжүүлж буй “Нэмүү өртгийн сүлжээ бий болгох нь” төслийн баг болон НҮБ-ийн суурин төлөөлөгч Тапан Мишра Винод Ахума тэргүүтэй хүмүүстэй гадаад харилцаа хамтын ажиллагааны чиглэлээр хийсэн уулзалтын зардалд 526 170 төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 3 311 643 /Гурван сая гурван зуун арван нэгэн мянга зургаан зуун дөчин гурван/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б. ДҮГЭРЖАВ

